

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

781.	Монгол Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай	Дугаар 63	3059
------	---	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

782.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 150	3060
------	---	------------	------

783.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 151	3060
------	---	------------	------

784.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 152	3061
------	---	------------	------

785.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 153	3061
------	---	------------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

786.	Журам батлах тухай	Дугаар 206	3062
------	--------------------	------------	------

787.	Жагсаалт батлах тухай	Дугаар 207	3065
------	-----------------------	------------	------



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар томилогдсонтой холбогдуулан өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын дэд даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio_02 YKIN HORG_02 Davaa.pdf

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠲᠤᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠲᠤᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠲᠤᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠲᠤᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 213 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Давааноровын Сувд-Эрдэнийг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 214 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Цэнддоржийн Амармэндийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 215 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Болдын Билгүүнийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Долоонжингийн Батхуягийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 16.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙДЫН ҮҮРЭГ
ХАРИУЦАГЧ**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 206 дугаар
тогтоолын хавсралт

**ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЦААСАН ХЭЛБЭРЭЭР
МЭДЭЭЛЭЛ ӨГӨХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДАЛ
ТООЦОХ АРГАЧЛАЛ, ЗАРДЛЫГ ТӨЛӨХ, ТҮҮНЭЭС
ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллийг цаасан хэлбэрээр өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.



1.2.Цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардлын хэмжээг энэ журмын 2.3-т заасан аргачлалд нийцүүлэн мэдээлэл хариуцагч тогтооно.

1.3.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан этгээд байна.

**Хоёр.Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр
мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал
тооцох аргачлал, зардлыг төлөх**

2.1.Цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхөд дараах зардлыг тооцно:

- 2.1.1.хэвлэх;
- 2.1.2.хуулбарлах;
- 2.1.3.шуудангаар илгээх.

2.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 16.5-д заасны дагуу хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарсан зардлыг хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээний хөлстэй давхардуулан авахгүй.

2.3.Мэдээлэл цаасан хэлбэрээр өгөхтэй холбогдон гарах зардлыг дараах аргачлалаар тооцно:

$$[TC]_{pi}=[P/pn + l/py] \cdot (1+\pi_t) \cdot [n]+Po$$

- TC_{pi} - мэдээлэл цаасан хэлбэрээр өгөхтэй холбогдон гарах зардлын нийт хэмжээ;

- P - өмнөх жилээр тооцсон нэг боодол А4 цаасны зах зээлийн дундаж үнэ;

- pn - нэг боодол А4 цаасны хуудасны тоо;

- l - өмнөх жилээр тооцсон нэг ширхэг принтерийн хорны цэнэглэгчийн зах зээлийн дундаж үнэ;

- py - нэг ширхэг принтерийн хорны цэнэглэгчийн хэвлэх, хуулбарлах нийт хуудасны тоо;

- π_t - тухайн жилийн тооцсон инфляц;

- n - мэдээллийн нийт хуудасны тоо;

- Po - шуудангийн зардал.



2.4.Хүн, хуулийн этгээд энэ журмын 2.3-т заасан аргачлалын дагуу тооцсон зардлыг мэдээлэл хариуцагчид төлнө.

**Гурав.Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр
мэдээлэл өгөх зардлаас хөнгөлөх, чөлөөлөх**

3.1.Мэдээлэл хариуцагч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг энэ журмын 2.1-д заасан зардлаас чөлөөлнө.

3.2.Хүн, хуулийн этгээд дараах мэдээллийг авахад энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан зардлаас хөнгөлнө:

3.2.1.Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, эсхүл олон улсын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олгох мэдээлэл;

3.2.2.хуульд зааснаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан бүрдүүлэх баримт бичиг;

3.2.3.хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, хүүхэд хамгаалахтай холбоотой баримт бичиг;

3.2.4.Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу хохирогчоос бүрдүүлэх баримт бичиг.

**Дөрөв.Хүн, хуулийн этгээдээс төлсөн
төлбөрийг буцаан олгох**

4.1.Хүн, хуулийн этгээдийн төлбөрийг дараах тохиолдолд буцаан олгоно:

4.1.1.тогтоосон хэмжээнээс илүү авсан;

4.1.2.хууль болон энэ журмын 3.1, 3.2-т заасны дагуу хөнгөлж, чөлөөлөхөөр заасан мэдээлэлд зардал тооцож авсан;

4.1.3.мэдээллийг хэвлэж, хувилахаас өмнө цаасан хэлбэрээр мэдээлэл авахаас татгалзсан.



Тав.Бусад

5.1.Мэдээлэл хариуцагч нь цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбоотой зардлын хэмжээ, түүнийг төлөх, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбоотой мэдээллийг өөрийн цахим хуудас болон тухайн байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан байна.

5.2.Хууль болон энэ журмын дагуу цаасан хэлбэрээр мэдээлэл өгсөнтэй холбогдуулан хүн, хуулийн этгээдээс авсан төлбөрийг мэдээлэл хариуцагч байгууллагын төсвийн урсгал санхүүжилтийн дансанд төвлөрүүлнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар), Зэвсэгт хүчний Жанжин штаб (Д.Ганзориг)-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙДЫН ҮҮРЭГ
ХАРИУЦАГЧ**

Л.ЭНХ-АМГАЛАН



Засгийн газрын 2022 оны 207 дугаар
тогтоолын хавсралт

**ОНЦ ЧУХАЛ МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦТЭЙ
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын нэр
1.	Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хяналт удирдлагын систем бүхий байгууллага	“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК
2.		“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
3.		“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК
4.		“Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК
5.		“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК
6.		“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК
7.		“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
8.		“Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
9.		“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК
10.		“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
11.		“Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх” ХХК
12.		“Хөвсгөл эрчим хүч” ХХК
13.		“Дөргөний усан цахилгаан станц” ХХК
14.		“Тосонцэнгэл усан цахилгаан станц” ХХК
15.		“Тайшир Гуулин усан цахилгаан станц” ХХК
16.		“Салхит” салхин цахилгаан станц
17.		“Цэций” салхин цахилгаан станц
18.		“Шанд” салхин цахилгаан станц



19.		Ус сувгийн удирдах газар
20.		Төв цэвэрлэх байгууламж
21.		“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК
22.		“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК
23.		“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК
24.		“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК
25.		“Ухаа худаг дулааны цахилгаан станц” ХХК
26.		“Багануурын дулааны станц” ТӨХК
27.		“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК
28.	Цэвэр, бохир ус, дулааны эх үүсвэр, төвлөрсөн хангамжийн болон түгээлт, хяналт, удирдлагын систем бүхий байгууллага	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК
29.		“Налайхын дулааны станц” ТӨХК
30.		“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК
31.		“Амгалан дулааны станц” ТӨХК
32.		“Дулаан Шарын гол” ТӨХК
33.		“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК
34.		“Хөвсгөлийн дулааны станц” ТӨХК
35.		“Ховд дулааны станц” ТӨХК
36.		“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК
37.		“Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ
38.		“Замын-Үүдийн дулааны станц” ТӨААТҮГ
39.		“Ар ус ундарга” ХХК
40.		“Чандмань Баянхонгор” ХХК
41.		“Суат” ХХК
42.		“Булганмээж” ХХК



43.		“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ
44.		“УСДУ” ОНӨААТҮГ
45.		“Дархан-Ус суваг” ХК
46.		“Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ
47.		“Чандмань-Илч” ХХК
48.		“Дундговь-Ус” ОНӨААТҮГ
49.		“Амь ус” ХХК
50.		“Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ
51.		“Дөрвөлж” ХХК
52.		“Төвчандмань ДЭХГ” ОНӨААТҮГ
53.		“Чандмань-Увс” ХХК
54.		“Онги-Ус суваг” ОНӨААТҮГ
55.		“Гүний-Ус” ХХК
56.		“Шим-Ус” ОНӨААТҮГ
57.		“Хэнтий-Ус” ОНӨХХК
58.		“Хөвсгөл ус суваг” ХХК
59.	Хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага (Лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллага болон Тусгай мэргэжлийн төв)	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
60.		Улсын хоёрдугаар төв эмнэлэг
61.		Улсын гуравдугаар төв эмнэлэг
62.		Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
63.		Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг
64.		Чингэлтэй дүүргийн Нэгдсэн эмнэлэг
65.		Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг



66.	Баянгол дүүргийн Нэгдсэн эмнэлэг
67.	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг
68.	Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг
69.	Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлэг
70.	Багануур дүүргийн Нэгдсэн эмнэлэг
71.	Багахангай дүүргийн Нэгдсэн эмнэлэг
72.	Хавдар судлалын үндэсний төв
73.	Арьсны өвчин судлалын үндэсний төв
74.	Гэмтэл, согог судлалын үндэсний төв
75.	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы хамтарсан эмнэлэг
76.	Амгалан амаржих газар
77.	Өргөө амаржих газар
78.	Хүрээ амаржих газар
79.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
80.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
81.	Цус сэлбэлт, судлалын үндэсний төв
82.	Геронтологийн үндэсний төв
83.	Эмгэг судлалын үндэсний төв
84.	Төмөр замын нэгдсэн эмнэлэг
85.	Цэргийн төв эмнэлэг
86.	Наркологийн эмнэлэг
87.	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг
88.	Өвөрхангай аймгийн Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг



89.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэг
90.	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг
91.	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэг
92.	Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлэг
93.	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
94.	Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
95.	Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
96.	Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
97.	Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
98.	Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэг
99.	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг
100.	Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэг
101.	Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг
102.	Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг
103.	Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг
104.	Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг
105.	Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
106.	Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
107.	Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг
108.	Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг
109.	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг
110.	Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг
111.	Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг
112.	Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг
113.	Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг



114.	Хүн, малын гоц халдварт өвчин судлах лаборатори	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
115.		Халдварт өвчин судлалын үндэсний төв
116.		Нийслэлийн зоонозын өвчин судлалын төв
117.	Эм, химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэгч байгууллага	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
118.		Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд
119.		Тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд
120.	Нэгдсэн төлбөр, тооцоо, гүйлгээний цахим систем бүхий банк, санхүүгийн байгууллага	Монголбанк
121.		Монголбанкны үндэсний цахим гүйлгээний төв
122.		“Хаан банк” ХХК
123.		“Худалдаа хөгжлийн банк” ХХК
124.		“Голомт банк” ХХК
125.		“Төрийн банк” ХХК
126.		“Капитрон банк” ХХК
127.		“Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК
128.		“Ариг банк” ХХК
129.		“Хас банк” ХХК
130.		“Чингис хаан банк” ХХК
131.		“Богд банк” ХХК
132.		“Тээвэр хөгжлийн банк” ХХК
133.		“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
134.	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК	



135.	Зүй ёсны монополю болон давамгай байдалтай харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээ эрхлэгч байгууллага	“Монголын цахилгаан холбоо” ХК
136.		“Монголшуудан” ХК
137.		“Мобиком корпораци” ХХК
138.		“Юнител” ХХК
139.		“ДДЭШТВ” ХХК
140.		“Жемнэт” ХХК
141.		“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ
142.		“Юнивишн” ХХК
143.		“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК
144.		“Мон корей топ ложистик” ХХК
145.		“Транс евро ази” ХХК
146.		“Бритлайн” ХХК
147.		“Би Даблю Ай Эс” ХХК
148.		“Аршгүүр” ХХК
149.	Агаарын зам, төмөр зам, усан зам, авто замын тээврийн зохицуулалт, хяналт, удирдлагын систем бүхий байгууллага	Иргэний нисэхийн ерөнхий газар
150.		Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба
151.		Замын хөдөлгөөний удирдлагын төв
152.		“Монголын төмөр зам” ТӨХК
153.		“Улаанбаатар төмөр зам” ХНН
154.		“Тавантолгой төмөр зам” ХХК
155.		“Чингис хаан” олон улсын нисэх буудал
156.		“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал
157.		“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ
158.		“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ



159.		Монгол Улсын далайн захиргаа
160.		“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ
161.		“Болд төмөр Ерөө гол” ХХК
162.		“Хялганат” ХХК
163.		“Эрдэнэс Монгол” ХХК
164.		“МИАТ” ТӨХК
165.		“Аэро Монголиа” ХХК
166.		“Хүннү Эйр” ХХК
167.	Түлш, шатахуун импортлогч, үйлдвэрлэгч, түгээгч байгууллага	“Шунхлай” ХХК
168.		“Петровис” ХХК
169.		“Содмонгол групп” ХХК
170.		“Магнай трэйд” ХХК
171.		“Тэс петролиум” ХХК
172.		“Монсульт” ХХК
173.		“Синчи ойл” ХХК
174.		“Ник” ХХК
175.		“М-Ойл групп” ХХК
176.		“Петрожамп” ХХК
177.		“Ай си ай си” ХХК
178.		“Жаст-ойл” ХХК
179.		“Оюу мандал” ХХК
180.		“Дашваанжил” ХХК
181.		“Юнигаз” ХХК
182.		“Горгаз” ХХК



183.		“Хийн тулга” ХХК
184.		“Нью энержи стар” ХХК
185.		“Лекс-ойл” ХХК
186.		“Ойнбирж” ХХК
187.		“Петро хаан” ХХК
188.		“Тод петролиум” ХХК
189.		“Петростар” ХХК
190.		“Ундарга-Увс” ХХК
191.		“Эн пи петролиум” ХХК
192.		“Хөрс” ХХК
193.	Мэдээлэл, шуурхай удирдлагын төв	Цагдаагийн ерөнхий газрын харьяа Мэдээлэл, шуурхай удирдлагын төв
194.		“Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төв” ОНӨААТҮГ
195.		Тээврийн цагдаагийн албаны Замын хөдөлгөөний удирдлага, хяналтын нэгдсэн төв
196.	Үндэсний олон нийтийн радио, телевиз	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
197.	Үндсэн болон дэмжих мэдээллийн систем, суурь мэдээллийн сан хариуцагч байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
198.		Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
199.		“И-Монгол академи” УТҮГ
200.	Дата төв, түүний салбар болон нөөц төвийн үйл ажиллагаа хариуцсан байгууллага	“Үндэсний дата төв” УТҮГ
201.		“Үндэсний дата төв” УТҮГ-ын нөөц төв
202.		“Айтүүлс” ХК
203.		“Мэйжикнэт” ХХК



204.	Хилийн боомтын хяналт, удирдлагын систем хариуцсан байгууллага болон улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн систем хариуцсан байгууллага	Гаалийн ерөнхий газар
205.		Хил хамгаалах ерөнхий газар
206.		Гадаадын иргэн, харьяатын газар
207.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах үйл ажиллагаа эрхлэгч байгууллага	“Тавантолгой” ХК
208.		“Энержиресурс” ХХК
209.		“Эрдэнэс Тавантолгой” ХК
210.		“Багануур” ХК
211.		“Шивээ овоо” ХХК
212.		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
213.		“Монголросцветмет” ТӨҮГ
214.		“Шарын гол” ХХК
215.		“Адуунчулуун” ХК
216.	Стратегийн хүнс үйлдвэрлэгч, хадгалагч, түгээгч байгууллага	Стратегийн хүнс үйлдвэрлэгч, хадгалагч, түгээгч мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий байгууллагууд

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003